



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны 11 сарын 13 өдөр

Дугаар 186

Номгон

Чандмань-Баянхонгор ХК-ний  
үйл ажиллагааны тайланг хэлэлцсэн тухай

Чандмань-Баянхонгор ХК нь 2018 оны 10 дугаар сарын 01-ний байдлаар 495142 м3 усыг олзворлож, 280 албан байгууллага, аж ахуйн нэгж, орон сууцны 2600 гаруй өрх, гэр хорооллын хэрэглэгчдэд цэвэр усыг түгээж, 346,5 мянган м3 саарал усыг татан зайлуулсан байна. Компаний орлого 1 256 620,0 төгрөг, авлага 68,5 сая төгрөг, өглөг 66,4 сая төгрөг, урт хугацаат зээл 105 сая төгрөг бөгөөд ажилчдынхаа тухтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 50 жилийн настай барилгын суурин дээр 100 хүүхдийн багтаамж бүхий цэцэрлэг, 2 давхар оффисын барилгыг улсын төсөв, орон нутгийн хөрөнгө, компанийн өөрийн хөрөнгөөр барьж 2017 оны 11 дүгээр сард ашиглалтад оруулсан зэрэг томоохон ажлыг хийж хэрэгжүүлснийг ТЭМДЭГЛЭЭД

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “а”, 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Чандмань-Баянхонгор” ХХК-ний 2018 оны үйл ажиллагааг “Хангалттай сайн” гэж дүгнэсүгэй.

ДАРГА  Ц.ОТГОНБАЯР

